



НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Шагналын журамд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Дүүргийн “Хүндэт иргэн” шалгаруулах болзол, журмын 3 дугаар зүйлд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

3.4 дэх заалт “Хүндэт иргэн” нь дүүрэг дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрхтэй, орон нутгийн өмчит сувилалын газарт хөнгөлөлт эдэлнэ”

3.5 дахь заалт Дүүргийн “Хүндэт иргэн”-ээр шагнуулсан иргэдэд энгэрийн тэмдэг, үнэмлэх олгох бөгөөд тэдгээр нь хөнгөлөлт урамшуулал эдлэх эрхийг төлөөлнө”


2. Тогтоолын нэмэлт өөрчлөлтийн хэрэгжилтийг хангуулах, шаардагдах төсөв хөрөнгийг хурлын төсөвт тусгуулан ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /А.Булбул/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НЭРГҮЙ

1126100041



ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ШАГНАЛД ТОДОРХОЙЛОХ БОЛОН ДҮҮРГИЙН УДИРДЛАГЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Дээд байгууллагын шагналд тодорхойлох

1.1 Иргэнийг Төрийн дээд шагналд тодорхойлохдоо Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан Монгол Улсын “Цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ын дагуу бүрдэл болсон материалыг дүүргийн Засаг дарга хүлээн авч, судалж үзээд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд өргөн барьж, хэлэлцүүлнэ.

1.2 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэрийг шагналын үндсэн материалын хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шагналын асуудал хариуцсан мэргэжилтэнд өгнө.

1.3 Монгол Улсын Засгийн газрын болон салбар яамдын шагналаар шагнуулах хүсэлтийг холбогдох журмын дагуу тухайн хамт олон нь санал гаргаж, дүүргийн Засаг даргад ирүүлснийг хянан үзэж зохих газруудад нь уламжилна.

1.4 Нийслэлийн удирдлагын шагналаар шагнуулах хүсэлтийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэл, дүүргийн удирдлагын шагналын төрөл, түүнийг олгох тухай журам”, Нийслэлийн Засаг даргын 2010 оны 796 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Засаг даргын шагналын төрөл, түүнийг олгох журам”-ын дагуу тухайн хамт олон нь гаргаж, Засаг даргын Тамгын газарт ирүүлснийг хянан үзэж шийдвэрлэнэ.

Хоёр. Дүүргийн удирдлагын шагнал

2.1 Дүүргийн удирдлагын шагнал нь 3 төрөл байна.

- 2.1.1 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хамтарсан шагнал,
- 2.1.2 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал,
- 2.1.3 Дүүргийн Засаг даргын шагнал,

2.2 Шагнал бүрийн хэлбэр, хийц нь ялгаатай байна.

Гурав. Дүүргийн удирдлагын хамтарсан шагнал

3.1 Хамтарсан шагналд:

- 3.1.1 Дүүргийн “Хүндэт иргэн”-д өргөмжлөх,
 - 3.1.2 Тэргүүний байгууллага, аж ахуйн нэгжид олгох шагнал
- 3.2 Оны ажил мэргэжлийн аварга болон тэргүүний ажилтнуудад олгох

3.3 Хамтарсан шагналаар шагнагдах хамт олон, иргэнд олгох мөнгөн шагнал, дагалдах зүйлийг Засаг дарга, Хурлын даргатай зөвшилцөж, Засаг даргын.

3.4 Хамтарсан шагналын “Өргөмжлөл” нь загвар хийцийн хувьд ялтсан дээр бичсэн зандан модон суурь бүхий байна.

Дөрөв. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал

4.1 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал нь

4.1.1 Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”

4.1.2 Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын “Жуух бичиг”

4.1.3 Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын “Баярын бичиг”

4.2 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал нь Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан журмаар зохицуулагдана.

Тав. Дүүргийн Засаг даргын шагнал

5.1 Дүүргийн Засаг даргын шагнал нь:

5.1.1 Дүүргийн “Хүндэт тэмдэг”,

5.1.2 Дүүргийн “Хүндэт дэвтэр”,

5.1.3 Дүүргийн Засаг даргын “Жуух бичиг”,

5.1.4 Дүүргийн Засаг даргын “Баярын бичиг”,

5.2 Дүүргийн Засаг даргын шагналаар шагнуулах асуудлыг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, хорооны санал болгон тодорхойлсноор Засаг даргын Тамгын газар хүлээн авч, 5.1.1, 5.1.2 дахь шагналыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 5.1.3, 5.1.4 дэх шагналыг Засаг дарга түүний Тамгын газрын холбогдох хэлтсүүдийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

5.3 Засаг даргын шагналуудын загвар, хийцийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батална.

Зургаа. Бусад

6.1 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналын дагалдах мөнгөн шагналыг Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1998 оны 23 дугаар тогтоолд заасан хэмжээг баримтлан үндсэн байгууллага, аж ахуйн нэгж нь хариуцан гаргана. Харин хамтарсан шагналын дагалдах мөнгөн хөрөнгийг дүүргийн төсвөөс гаргана.

6.2 Шагналд зарцуулах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж байна.



ДҮҮРГИЙН “ХҮНДЭТ ИРГЭН” ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛ, ЖУРАМ

Зорилго: Налайх дүүргийг хөгжүүлэхэд идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж, жинтэй хувь нэмэр оруулсан иргэнийг дүүргийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжилж алдаршуулахад энэ журмыг мөрдөнө.

Нэг. Шалгаруулах үзүүлэлт

1.1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжил, гадаад харилцааг хөгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж, жинтэй хувь нэмэр оруулсан тус дүүргийн харьяат болон харьяат бус, олон түмэнд нэр хүндтэй, ял шийтгэлгүй, төрийн болон төрийн бус байгууллагын удирдах ажилтан, мэргэжилтэн, бизнес эрхлэгч, нийгэм, соёлын ажилтан, иргэнийг дүүргийн “Хүндэт иргэн”-ээр шалгаруулна.

Хоёр. Шалгаруулалт

2.1 Энэхүү болзол журмын заалтыг бүрэн хангасан иргэнийг дүүргийн баяр наадмаар “Хүндэт иргэн”-ээр шалгаруулж байна.

2.2 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг дарга, түүний Тамгын газар “Хүндэт иргэн”-ээр шалгаруулах иргэний нэрийг дэвшүүлж, нэр дэвшүүлсэн иргэнийхээ анкет, тодорхойлолтыг Засаг даргад тухайн оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ.

2.3 Дүүргийн Засаг дарга “Хүндэт иргэн”-д нэр дэвшүүлсэн иргэний тодорхойлолт, холбогдох бусад материалыг үндэслэн тухай бүрт нь тусгай комисс томилон шалгуулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргаж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн барина.

2.4 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Тэргүүлэгчдийнхээ хурлаар авч хэлэлцэж, эцсийн шийдвэр гаргана.

Гурав. Шагнал олголт


3.1. Дүүргийн “Хүндэт иргэн”-ээр шалгарсан иргэнд Налайх дүүргийн “Хүндэт иргэн” цол өргөмжилж, хүндэт иргэний тэмдэг, үнэмлэх 300 000 төгрөгөөр шагнана.

3.2. Хүндэт иргэнийг жил бүр дүүргийн баяр наадмаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ.

3.3. Хүндэт иргэн нь дүүргийн төр, захиргааны болон үйлчилгээний байгууллагад дараалал харгалзахгүй үйлчлүүлнэ.

3.4. “Хүндэт иргэн нь дүүрэг дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрхтэй, орон нутгийн өмчит сувилалын газарт хөнгөлөлт эдэлнэ.

3.5. Дүүргийн “Хүндэт иргэн”-ээр шагнуулагчдад энгэрийн тэмдэг, үнэмлэх олгох бөгөөд тэдгээр нь хөнгөлөлт урамшуулал эдлэх эрхийг төлөөлнө.



НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШАГНАЛААР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1 Налайх дүүргийг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан, нутгийн өөрөө удирдах ёсыг дэмжиж ажилладаг, эрхэлсэн ажилдаа амжилт, үр бүтээл гаргасан, Налайх дүүрэгт удаан жил ажиллаж, амьдрахын зэрэгцээ шинэ бүтээл, санал санаачилга гаргасан хүмүүсийг шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх, өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлан, шийдвэрлэх, шагнал гардуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал:

2.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах шагналтай байна.

2.1.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт өргөмжлөл",

2.1.2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын "Жуух бичиг",

2.1.3. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын "Баярын бичиг",

2.2. Шагналыг шат дараалуулан, ажлын амжилт, бүтээлийн өсөлтөөр нь олгох зарчмыг баримтална.

2.3. Шагналыг дараах зарчмыг баримтлан олгоно.

2.3.1. "Хүндэт өргөмжлөл"-өөр хурлын байгууллагатай нягт хамтран ажилладаг, нутгийн өөрөө удирдах ёсыг дэмжин ажилладаг байгууллага хувь хүнийг шагнана,

2.3.2. "Жуух бичиг"-ээр байгууллагын ой, тэмдэглэлт баяр болон дүүргийн хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрээ оруулсан ажилтныг шагнаж урамшуулна.

2.3.3. "Баярын бичиг"-ээр байгууллагын ой, тэмдэглэлт баяраар байгууллага хамт олноо хошуучлан ажилласан ажилтныг шагнаж урамшуулна.

2.4. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал дараах хийц загвартай байна.

2.4. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал дараах хийц загвартай байна.

2.4.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт Өргөмжлөл" нь улаан хамбан гадартай, алтан шаргал өнгөөр дүүргийн бэлгэ тэмдэг, "Хүндэт Өргөмжлөл" гэсэн үгнүүдийг бичсэн хавтастай байна. Өргөмжлөлийн дотор зүүн талд дүүргийн бэлэг тэмдэг, дугаартай, Баруун талд шагналын нэр, шагнагдагчийн овог нэр, талархлын үг түүний дараа Хурлын гарын үсэг зурах зайг үлдээж гарын үсгийн тайллын хамт бичиж, шагнал олгосон огноог бичнэ. Талархлын үг нэг загвартай байх бөгөөд ажлын албанаас боловсруулсан байна.

2.4.2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын "Жуух бичиг" нь улаан хавтастай, алтан шаргал өнгийн дүүргийн бэлгэ тэмдэг, "Жуух бичиг" гэсэн үгнүүдийг бичсэн хавтастай байна. "Жуух бичиг"-ийн дотор зүүн талд дүүргийн бэлгэ тэмдэг, дугаартай, Баруун талд шагналын нэр, шагнагдагчийн овог нэр, талархлын үг түүний дараа Хурлын гарын үсэг зурах зайг үлдээж гарын үсгийн тайллын хамт бичнэ. Талархлын үг нэг загвартай байх бөгөөд ажлын албанаас боловсруулсан байна.

2.4.3. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын "Баярын бичиг" нь хөх хавтастай, алтан шаргал өнгийн дүүргийн бэлгэ тэмдэг, "Баярын бичиг" гэсэн үгнүүдийг бичсэн хавтастай байна. "Баярын бичиг"-ийн дотор зүүн талд дүүргийн бэлгэ тэмдэг, дугаартай, Баруун талд шагналын нэр, шагнагдагчийн овог нэр, талархлын үг түүний дараа Хурлын гарын үсэг зурах зайг үлдээж гарын үсгийн тайллын хамт бичнэ. Талархлын үг нэг загвартай байх бөгөөд ажлын албанаас боловсруулсан байна.

2.4.4. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт Өргөмжлөл", "Жуух бичиг", "Баярын бичиг"-т хурлын дарга гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, өргөн мэдүүлэх

3.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Хүндэт өргөмжлөл"-өөр шагнуулах асуудлаар хороо, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, нэр дэвшүүлэн санал гаргана.

3.2. Дүүргийн Засаг дарга нэр дэвшүүлэх санал гаргаж болно.

3.3. Нэр дэвшсэн байгууллага, ажилтан, иргэдийг хамтын удирдлагын хурлаараа хэлэлцэж тодорхойлолт гаргана.

3.4. Тодорхойлолтод шагналд нэр дэвшигч ямар санаачилга, үр бүтээл гаргасан, дүүргийн хөгжил болон нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэхэд ямар хувь нэмэр оруулсан тухай баримтаар дурдаж, байгууллагын дарга гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна.

3.5. Шагнуулах нэр дэвшигчийн анкет, тодорхойлолтыг ямар шагналаар шагнуулах саналын хамт албан бичгээр Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

3.6. Хурлын даргад өргөн мэдүүлсэн тодорхойлолт, анкет болон холбогдох баримт бичгийн бүрдэл, агуулгыг Хурлын ажлын алба ажлын 5-10 хоногт багтааж судлан санал боловсруулж, шийдвэрийн төслийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, Хурлын даргад танилцуулна.

Дөрөв. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнах асуудлыг шийдвэрлэх, шагнал гардуулах, мэдээлэх

4.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнахад Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гаргана.

4.2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын “Жуух бичиг”-ээр шагнуулах асуудлыг Хурлын дарга шийдвэрлэнэ.

4.3. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Баярын бичиг”-ээр шагнуулах асуудлыг Хурлын дарга шийдвэрлэнэ.

4.4. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналыг Хурлын дарга гардуулах бөгөөд Хурлын даргын даалгавраар Хурлын нарийн бичгийн дарга, Тэргүүлэгчид гардуулж болно,

4.5. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнасан, шагнал гардуулсан тухай орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, хурлын веб сайтаар нийтэд мэдээлнэ.

Тав. Бусад

5.1. Шагналд зарцуулах хөрөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын жил бүрийн төсөвт тусгаж байна.

5.2. Шагналд тодорхойлох анкет дараах загвартай байна.

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
.....-ЭЭР
ШАГНУУЛАХААР ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ АНКЕТ

1. Эцэг (эх)-ийн нэр:
2. Нэр:
3. Төрсөн огноо:
4. Хүйс:
5. Төрсөн аймаг, сум, хот:
6. Одоогийн харьяалал: Налайх дүүргийн дугаар хороо -тоот
7. Нийгмийн байдал:
8. Регистрийн дугаар:
9. Боловсрол:
10. Ажилладаг салбар:
11. Мэргэжил:
12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1			
2.			

13. Урьд шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд
1.		
2.		

14. Шагнуулах үндэслэл:
15. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:
16. Хамт олны санал: